# 2020-2021 МБС-ын улсын Эрдэм шинжилгээний нийтлэлийн уралдаанд орсон судалгааны ажил

2021 он

## Говьсүмбэр аймаг дахь УУЖС Политехник коллежийн
## Цахим сургалтын систем

*Эдийн засаг, бизнесийн ухааны багш бизнесийн удирдлагын магитср, ахлах багш:М.Баярмаа*

*Сургалтын албаны арга зүйч, Боловсролын ухааны Магистр ахлах багш: Ж.Норжмаа*

*ЗААА-ны менежер: П.Мөнхцоож*

*Гагнуурын мастер багш: Т.Эрхэмбаяр*

*Веб мультимедиагийн багш:М.Сандагсүрэн*

Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 2019-2021 оны хичээлийн жилүүдэд цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг явуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага гарсан. Цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулахад техник технологи, суралцагчид хүргэх арга зам, хүртээмж, эргэх холбоо, үнэлгээ гэх мэт зүйлс тулгамдаж байгаа нь манай сургууль төдийгүй салбарын хэмжээнд тулгамдсан асуудал болсон

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд манай сургуулийн дэргэдэх “New solution” баг цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулах мөн сургуулийн инноваци хөгжүүлэх гарааны компани бий болгох чиглэл бүхий зорилтот ажлуудыг санаачлан үе шаттайгаар хийсээр байна. 2019 оны 1-р сард ХНХЯ, БСШУЯ, Говьсүмбэр ПТК-ийн хамтарсан “Шинэ-санаа, Шилдэг-Инноваци” уралдааныг сургуулийн хэмжээнд зохион байгуулсан. Тус уралдаанд “УУЖС сургууль ПТК-ийн мэдээ мэдээллийн нэгдсэн системийг бий болгох нь” сэдэвт төсөл хэрэгжүүлж эхлүүлсэн нь энэхүү уралдаанд оролцох үндэс болж мөн цаашид хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлсэн таатай санал санаачлага боллоо.

Цахим сургалтыг зохион байгуулах ажил нь цаг хугацааны хувьд гэнэтийн хүчин зүйл болж багш төдийгүй сургалтын байгууллагын хувьд цахим сургалтын нэгдсэн бааз, цахим материалууд бэлтгэх, хүргэх, суралцагчдыг үнэлэх, дүгнэх, шалгалт зохион байгуулах, ҮСД-ыг зохион байгуулах, тайлан хамгаалуулах, төгсөлтийн шалгалтыг авах, өгөх нь зөвхөн сошиал сүлжээг ашиглах төдийхнөөр явагдаж байсан. Үүгээр зогсохгүй багш нарын ажлыг үнэлж, дүгнэхэд ч удирдлагуудын хувьд бэрхшээлтэй болж эхэлсэн.

Иймд суралцагчдад чанартай сургалт хүргэхийн тулд сургуулийн үйл ажиллагааны онцлогт тохирсон шинэлэг технологийг нэвтрүүлэх шаардлага гарч, 2019 онд эхлүүлсэн цахим сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэн үр дүнг харж ажиллаж байгаа нь амжилттай болж, цаашид тогтмолжуулан, түгээн дэлгэрүүлэх ажлууд дээр илүү анхаарал хандуулан ажиллаж байна.

Бидний эхлүүлсэн цахим сургалтын систем нь олон улсын сургалтын номер

1 платформ болох MOODLE-ийг ашиглан мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлж, жилийн нэгдсэн график, сургалтын төлөвлөгөө, ажлын төлөвлөгөө болон тайлан, бүх төрлийн зар мэдээ, сургалт, семинар, хичээл, шалгалтын хуваарь, хичээлийн хөтөлбөр зэрэг цаасаар хийгддэг ажлууд бүгд цахим хэлбэрт шилжин, багш нарын хичээлийн нэгдсэн сантай болж, цаашлаад суралцагчдын сургалтын үйл ажиллагааг явуулах, онол болон дадлагын хичээлийг үр дүнтэй хүргэх, нарийвчилсан сургалтын үнэлгээ, танилцах дадлагыг хийлгэх боломж бүрдсэн. Мөн ажил олгогч болон нийгмийн түншлэлийн харилцааг бий болгож хамтрагч байгууллагатай хамтран ажиллах боломжийг ч мөн бүрдүүлсэн.

Бидний хамгийн чухал объект болох суралцагчдад илүү ойлгомжтой, хүртээмжтэй, ашиглахад хялбар аппликейшн, мөн заавал өндөр хурдны интернетийн шаардлагагүйгээр оффлайн хэлбэрээр ашиглах боломжтой болсон нь илүү үр дүнтэй болж өгсөн.

Тухайн мэдээллийн систем нь байгууллагын үйл ажиллагааг дэмжих, автоматжуулах, удирдлагын шийдвэр гаргалтанд шаардлагатай мэдээллээр цаг тухайд хангах, мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох боломжийг бүрдүүлсэн. Үүнээс гадна зөвхөн мэдээллийг боловсруулах технологи биш, түүнийг хариуцан ажиллуулах, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, мэдээллийн нууцыг хадгалах, оюуны өмчийг хамгаалах, цаас хэмнэсэн эко ногоон хөгжлийг дэмжсэн олон талт үр дүнг бий болгож өглөө.

Цаашид хөгжүүлэх зүйлс нь хурууны хээ, нүүр таних бүртгэлийн системийг оруулах, суралцагчдын ирцийн мэдээллийг автоматжуулах, багш нарын сургалтын явцыг дүрсжүүлж, цахим системд оруулах, нийгмийн түншлэл, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн суралцагчийг сонгон ажилд авах боломжийг бүрдүүлэх, салбар яам, үнэлгээний төвтэй мэдээллийн системээ холбож өгөх, цахим мэдээллийн системийг патентжуулах ажлыг гараанЫ компаниар дамжуулан хийж, цаашид нийтэд түгээх боломжийг судлан ажиллах болно.

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НИЙТЛЭЛ

## ШАТАЛСАН ЦАХИМ СУРГАЛТААР БАГШ НАРЫН МЭДЛЭГ УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ

**Зохион байгуулагч**
Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

**Хамрах хүрээ**
Мэргэжлийн боловсролын багш нар

**Зохион байгуулах хэлбэр**
Цахим зайны сургалт GOOGLE GMAIL ашиглан

**Хамтран зохион байгуулагч**
Мэргэжлийн боловсрол сургалтын Үнэлгээний төв

**Хугацаа**
1-р үе 2020 оны 11 сарын 15-2021 оны 3 сарын 15

Гидравликийн багш Б. Мэндбаяр утас 99401161 мэйл mendbayar.tvet@Gmail.com
Арга зүйч Ц. Мягмарсүрэн утас 88723219 мэйл tvetmyagmarsuren@Gmail.com

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

## Нийтлэлийн бүтэц

- Нийтлэлийн үндэслэл
- Зорилго зорилт
- Хамрах хүрээ
- Туршилт судалгаа
- Тулгамдсан асуудал
- Тулгамдсан асуудлын шийдэл
- Цахим сургалт
- Төлөвлөгөө
- Гарах үр дүн
- ДҮГНЭЛТ

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

## Нийтлэлийн үндэслэл

**Сүүлийн жилүүдэд бүх төрлийн технологи шинэчлэгдэхийн хэрээр бүхийл салбарт ажиллаж байгаа ажилтан, инженер, техникч, эмч, багш, санхүүгийн ажилтан, мэргэжилтнүүд гэх зэрэг олон салбарт өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх шаардлага гарч ирээд байгаа боловч тэр шаардлагад хангах сургалт орон нутагт байхгүй ,мөн өөрийн цаг зав муу байдгаас шалтгаалан эдгээр ажил хийдэг оролцогчдод дараах зайны mail суурилсан сургалтын санал болгож энэ төслийг эхлүүлж байна.**



Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

## Зорилго .

Судалгааны ажлын хүрээнд зайны сургалтын төсөл орон нутагт хэрэгжүүлж зайны сургалт зохион байгуулж мэргэжлийн боловсролын салбарын багш нарын цахим мэдлэг ур чадварыг сайжруулах.



Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

## Зорилт

- **Багийн мэдлэг ур чадварын шаталсан сургалт зохион байгуулж сайжруулах.**
- **МСҮТөв болон ПТКоллежийн багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах**
- **Инновацийн уралдаанд амжилттай оролцох.**
- **Цахим зайны сургалт 2 төслөөр Говийн бүсийн 5 сургуулийн Багш нарыг хамруулна.**



Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

## Хамрах хүрээ

- Цахим хичээл 1 төслөөр ГСА ПТК-н 36 багшийг хамруулах
- Цахим хичээл 2 төслөөр Говийн бүсийн 3 сургуулийн 90 багшийг хамруулах
- Цахим хичээл 2 төслөөр Говийн бүсийн 5 сургуулийн 120 багшийг хамруулах

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Туршилт судалгаа

### Туршилт

- Цахим хичээл 1 төслийг 2020 оны 11 сарын 15 наас эхлүүлээд Говьсүмбэр аймгийн ПТК 36 багш Бор Өндөр МСҮТ 12 багш эхлүүлсэн Цахим хичээл 4-р шат хүртэл үргэлжилж байгаа одоо 13 баг үргэжлүүлэн оролцож байгаа.

| Үе | Цахим хичээл илгээх хугацаа | Даалгавараа хийж төслийн багт илгээх хугацаа |
|---|---|---|
| 1-р | 2020,11,15 | 2020,11.30 |
| 2-р | 2020,12,01 | 2020,12,15 |
| 3-р | 2020,12,15 | 2020,12,29 |

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Туршилт судалгаа

### Судалгаа

Судалгааны ажлын хүрээнд нийт 3 судалгаа хийнэ. Төсөлт ажлын 1 үе буюу гарааны судалгаа. Төсөлт ажлын явцын судалгаа 4 үе дээр авна. Төсөлт ажлын үр дүнгийн судалгаа буюу 8 үедээ авч судалгааны тайлан бичнэ.



Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Цахим хичээл 1 явцын судалгаа

Нийт 36 багш

- Мэргэжлийн 17
- Ерөнхий эрдэмийн 15
- Сургалтын алба 4




Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Цахим хичээл 1 явцын судалгаа

Нийт 36 багш нас

- 20-30 -4
- 30-40-20
- 40-50-10
- 50-60-2




Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Цахим хичээл 1 явцын судалгаа

2-р шатанд

- нийт -36
- Оролцсон 28




Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Цахим хичээл 1 явцын судалгаа

3-р шатанд

- нийт -36
- Оролцсон 14



## Цахим хичээл 1 явцын судалгаа

3 шатанд

- нийт -36
- Оролцсон 13






## Цахим хичээл 1 явцын судалгаа 4-р шат шатанд

Нийт 13 багш

- Мэргэжлийн 4
- Ерөнхий эрдэмийн 6
- Сургалтын алба 3






## Цахим хичээл 1 явцын судалгаа 3 шатанд

Нийт13 багш нас

- 20-30 -1
- 30-40-10
- 40-50-2
- 50-60-0



## Цахим хичээл 1 явцын судалгааны дүгнэлт

- Цахим хичээл 1 хичээл 3 даалгавараа явуулсан 4-р шатанд тэнцсэн 13 багш тэнцсэн 36% оролцож байна.
- Багшийн 47% Мэйлийг сайн ашигдаггүй
- 8 багш буюу багш нарын мэйл хаяг байхгүй
- 8 багш мэйл хаяг нээж өгсөн 1-р шатны даалгавар хийж өгөлгүй хасагдсан
- Цахим сургалтын үед багш нарын ачаалал их байсан.
- Залуу багш нарын оролцоо сул байсан
- 50-40 дээш настай багш цахим мэдлэг сул байсан.





## Тулгамдсан асуудал

- мэдлэг байгаа ч бусдад түгээх болон мэдлэгээ ил гаргах хандлага алга → **Хувь хүний хандлага** ← Мэдлэг нь тухайн үйл ажиллагаанд тэнцэж байгаа ч хийе болгоё гэсэн хандлагагүй
- Компьютерийн мэдлэггүй хүн сэтгэл байвч хийхэд бэрхшээлтэй байна → **Хувь хүний мэдлэг ур чадвар** ← Хувь хүний суурь мэдлэг бас нөлөөлж байна
- 50-аас дээш насны хүмүүс мэдээлэл хүлээж авч суралцахад удаан байдаг → **Насны онцлог** ← Бага залуу насны хүмүүс мэдээлэл хурдан хүлээж авах хэдий ч өнгөц төдий л ажиллаж байна.



## Тулгамдсан асуудал шийдэл

**Хувь хүний хандлага**

- Сургалтын алба хандлагын сургалт хийх.
- 2021-2022 хичээлийн жил төлөвлөгөөнд цахим зайны сургалтаар өөрийгөө хөгжүүлэх гэж оруулах

**Хувь хүний мэдлэг ур чадвар**

- Өөрийгөө хөгжүүлэх сургалт СА хамтарч зохион байгуулах.
- СА төлөвлөгөөт цахим сургалт хийх.

**Насны онцлог**

- 50-аас дээш насны багш нартаа тусгайлсан сургалт явуулах.
- Залуу багш нарын оролцоог дэмжих өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө сургалтын алба авах.

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Цахим сургалт

Зайны сургалт хийх аргачлал технологи дараалал
Цахим хичээлийн бүрдэл
Цахим сургалтын агуулга

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Зайны сургалт хийх аргачлал технологи дараалал



Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Цахим хичээлийн бүрдэл

- Цахим зааварчилгаа
- Видео хичээл
- Цахим хичээлийн даалгавар

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Цахим сургалтын агуулга

1-р шат
- Мэйл бичих арга зүй
- Жмэйл тохиргоо нэмэлт боломжууд

2-р шат
- Жмэйл гарын үсэг оруулах
- Дэлгэц хэвлэх арга

3-р шат
- Гарын үсэгт зураг оруулах
- Дэлгэц бичих арга Bandi cam

4-р шат
- 4-8 шат хүртэл Судлах хичээлийн судалгаа авна.

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Цахим сургалтын хугацаа

| Үе | Цахим хичээл илгээх хугацаа | Даалгавараа хийж төслийн багт илгээх хугацаа |
|---|---|---|
| 1-р | 2020,11,15 | 2020,11.30 |
| 2-р | 2020,12,01 | 2020,12,15 |
| 3-р | 2020,12,15 | 2020,12,29 |
| 4-р | 2021,01,01 | 2021,01,15 |

| Үе | Цахим хичээл илгээх хугацаа | Даалгавараа хийж төслийн багт илгээх хугацаа |
|---|---|---|
| 5-р | 2021,01,15 | 2021,01,30 |
| 6-р | 2021,02,01 | 2021,02,15 |
| 7-р | 2021,02,15 | 2021,02,28 |
| 8-р | 2021,03,01 | 2021,03,15 |

Говьсүмбэр аймаг
дахь Политехник коллеж

# Цахим видео хичээл



## Судалгааны ажлын төлөвлөгөө

| № | Хийгдэх ажил | Хугацаа | Гарах зардал | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Төсөл бичих | 2019.10.31 | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| 2 | Төслийн гарааны сургалт | 2019.11.10-11.15 | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| 3 | Оролцогчдод цахим мэдээлэл боловсруулах. | 2019.11.16-2020.03.15 | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| 4 | Цахим хичээл балдах | байхгүй | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| 5 | Оролцогчдын даалгаварыг шалган 1-8 үеийн онлайн даалгавар явуулах. | 2019.11.16-2020.03.15 | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| 6 | Багийн оролдлогын тооцоо гаргах | 2020.01.15-2020.03.15 | байхгүй | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |

## Судалгааны ажлын төлөвлөгөө

| № | Хийгдэх ажил | Хугацаа | Гарах зардал | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 8 | Цахим хичээл DVD шарах | 2021.03.10 | 50*5000=250.000 | Б. Мэндбаяр |
| 9 | Гэрчилгээ гардуулах | 2021.03.20 | байхгүй | Багийн гишүүд оролцогчид |
| 10 | Бүтээлийн патент авах. | 2021.03.20-03.30 | Патентын үнэ 30,000 | Б. Мэндбаяр Ц. Мягмарсүрэн |
| | Нийт гарах зардал | | 1.030.000 | |

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Гарсан үр дүн

- Багш нар шатлан суралцах боломжтой.
- Багш нар нэг даалгавар хийхийн тул цахим видео хичээл 2-5 дахин үзэж өөрийгөө хөгжүүлж байгаа.
- Цахим хичээл Gmail ашиглан явуулж байгаа тул өртөг зардалгүй.
- Даалгавар хийгээгүй багш цахим хичээлийн дараагийн шатанд орохгүй тул хариуцлагатай болно.
- Багш нарын мэйл бичих чадвар соёл сайжирсан,
- Цахим хичээл 8 шатны хичээл бүрэн дууссаны дараа цахим хичээл ADOBE CAPTIVATE программ хийж оролцогчдод өгнө.
- Сургуулийн захиргаа сургалтын алба сайн дэмжиж байгаа.
- Орон нутгийн ЗДТГ сургалт авах захиалга ирсэн.
- Зохион байгуулагч нар орлого олох боломжтой.



Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Гарсан үр дүн

- Зайны шаталсан сургалтын баг шинэ бүтээлийн патент авна.
- Зайны шаталсан сургалтын баг ажлын бүтээмж сайжирна.
- Зайны шаталсан сургалтын баг орлого нэмэгдэнэ.
- Инновацийн улсын уралдаанд оролцоно.
- Зайны шаталсан сургалт ГСА ПТК 36 багшид эхлүүлээд явж байгаа бөгөөд цахим сургалтын 4 шатанд 13 багш оролцоод явж байгаа.
- Орцоод явж байгаа багш нарийн сэтгэл маш өндөр байгаа.
- Цахим хичээл 8 үе шатаа бүрэн судалсан багш нарт сургуулийн захиргаанаас 2 кредит цагийн гэрчилгээ олгож урамшуулна.



## Гарсан үр дүн

- Цахим хичээлд оролцогч М. Баярмаа багшийн Дэлгэц бичих аргаар хийсэн цахим даалгаварын бичлэг




## Гарсан үр дүн

- Цахим хичээлд оролцогч А. Чулуунчимэг багшийн Дэлгэц бичих аргаар хийсэн цахим даалгаварын бичлэг



## Гарсан үр дүн

Багш нарын мэйл бичих чадвар сайжирсан

**Сургалтаас өмнө**



Jinsodov Norjmaa

Даалгавар 3-ыг хүлээн авлаа.

**Цахим хичээл 3 сургалтын дараа**



---

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Цахим сургалтанд гарсан асуудал

- **Багш нарын цахим мэдлэгийг дээшлүүлэхээр 36 багшийг хамруулж 8 багшид шинэ мэйл хаяг нээж оролцуулсан боловч 7 багш оролцоогүй.**
- **Багшийн өөрийгөө хөгжүүлэх ордлого сул**
- **Зарим багш нарийн хувь цахим мэдлэг дэндүү сул байсан.**
- **Насны онцлог нас залуу багш нар хариуцлагагүй оролцоо сул байхад 50 дээш насны багш цахим мэдлэг чадвар маш муу.**
- **Зарим багш нар мэйл байдагч ашиглах чадвар болон хэрэглээ байхгүй.**
- **Зарим багш нар эдийн засгын хөшүүрэг болон цалин мөнгөн дээр нэмэгдэл урамшуулал өгнө гэсэн юманд хийдэг тийм хөшүүрэг байхгүй бол хийддэгүй нь ажигладсан.**



---

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Дүгнэлт

### Зорилго

**Судалгааны ажлын хүрээнд зайны сургалтын төсөл орон нутагт хэрэгжүүлж зайны сургалт зохион байгуулж мэргэжлийн боловсролын салбарын багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах.**

### Үр дүн

**Зайны шаталсан сургалт ГСА ПТК 36 багшид эхлүүлээд явж байгаа бөгөөд цахим сургалтын 4 шатанд 13 багш оролцоод явж байгаа.**

---

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

## Дүгнэлт

### Зорилт

- **Багын мэдлэг ур чадварын шаталсан сургалт зохион байгуулж сайжруулах.**
- **МСҮТөв болон ПТКоллежийн багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах**
- **Инновацийн уралдаанд амжилттай оролцох.**
- **Цахим зайны сургалт 2 төслөөр Говийн бүсийн 5 сургуулийн Багш нарыг хамруулна.**

### Үр дүн

- **Багийн мэдлэг ур чадварын шаталсан сургалт зохион байгуулж сайжирч байгаа**
- **МСҮТөв болон ПТКоллежийн багш 36 багш зайны шаталсан сургалтанд хамруулж 4 шатанд 13 багш хамрагдаад явж байгаа**
- **Инновацийн уралдаанд амжилттай оролцож байгаа**
- **Цахим зайны сургалт 2 төслөөр Говийн бүсийн 5 сургуулийн Багш нарыг хамруулах бэлтгэл хангагдсан.**

## Цахим сургалтыг чанартай хүртээмжтэй зохион байгуулах нь

Гэнэтийн аюулт өвчин, цар тахал нь хүн төрөлхтөнийг аливаа шинэ зүйлд дасан зохиоцох, шинэ арга барилд суралцах, шинэ орчин нөхцөлд ажилж амьдрах шалгуурыг тавьж байна. Цахим сургалт зайн сургалт гэдэг зүйл өмнө нь яригдаж судлагдаж туршигдаж байсан ч тийм ч цар хүрээгээ тэлж нийтлэг болж чадаагүй зүйлээ. Харин 2020 оны 1 сараас дэлхий нийт аюулт өвчинтэй нүүр тулж ажил амьдрал хэвийн горимоороо явагдах боломжгүй болж бидний хойч ирээдүй болсон үр хүүхэд, оюутан залуус маань цахимаар суралцах шинэ арга барилыг эзэмшиж байна. Монгол улсын харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан 2018.12.31- ны судалгаагаар доор харуулвал:

Ухаалаг гар утас хэрэглэгчийн тоо -3,302,052




Интернет хэрэглэгчдийн тоог авч үзвэл:




Эх сурвалж: 1212.mn, https://crc.gov.mn/

Судалгаанаас үзэхэд ухаалаг гар утас, интернет хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлт харагдаж байна. Эндээс үзэхэд онлайнаар суралцах нөхцөл боломж харьцангуй сайн байна. Саяхан миний ажилладаг сургууль болох Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь Covid 19 өвчинтэй холбоотойгоор 2 болон 3-р курсийн тайлан хамгаалалтаа Google meet программ ашиглан онлайнаар хамгаалуулсан ба нийт суралцагчдын 90-ээс дээш хувь нь хамрагдсан. Эндээс үзэхэд оюутан суралцагчид маань нийгэм цаг үеэ дагаад онлайн хэрэглээ сайн байгаа нь харагдаж байна. Гагцхүү бид суралцагчдынхаа суралцах хандлага төлөвшлийг хэрхэн сайжруулах вэ? Тэдний сурах идэвхийг хэрхэн өрнүүлэх вэ? гэдэг асуултууд гарч ирж байна. Багш нар хичээлээ ангиудын группт тавьж хийх заавар зөвлөмжийг өгдөгч хичээлээ чанартай хийж, багшруугаа явуулж буй суралцагчдын тоо цөөн, багшийн даалгаврыг хараад өнгөрөх асуудал их байна. Миний хувьд энэ жил төгсөх ангитай тул тайлан хамгаалалтад ангийн суралцагчдаа 100 хувь хамруулах, хичээлүүдийг маш сайн үр дүнтэй хийлгүүлэх зайлшгүй шаардлага байсан тул нэгдүгээрт ангийн суралцагчидтай Zoom программ ашиглан холбогдож хурал хийсэн. Харин сургуулиас дадлагын тайлан хамгаалалтыг Google meet программ ашиглан хамгаалуулах чиглэл өгсөн тул энэхүү программыг ашиглан хэд хэдэн удаа холбогдож тайлан хамгаалах заавар зөвлөгөөг өгч ажилласан ба анги маань тайлан хамгаалалтдаа 100 хувь орсон. Харин одоогоор өөрийн хичээлийн онлайн сургалтыг хэрхэн сайжруулах, суралцагчдаа компьютер утасны цаанаас хэрхэн идэвхжүүлэх арга барилд суралцах, хэрхэн сонирхолтой хичээл бэлтгэх арга зүйд суралцаж хичээлээ боловсруулж байна. Шинэ сургалтын арга зүйг судлахаас гадна сонирхолтой хичээл бэлтгэх видео хичээлүүдийг үзэж судлан өмнө нь мэддэггүй олон зүйлсээ мэдэж авч байна. Аливаа зүйлийг бүтэхгүй болохгүй талаас харвал бэрхшээл саад мундахгүй. Харин хийх гэж оролдвол болгох гэж үзвэл бэрхшээлийг ч боломж болгож болох юм.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн Англи хэлний багш

А.Чулуунчимэг